

БАТЛАВ.

ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ОЮУНСАНАА

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ӨНДӨГ ХУСАЖ ЦУГЛУУЛАХ МЕХАНИК АРГААР 3500 ГА ТАЛБАЙД ТЭМЦЭХ АЖИЛ

ТЭМЦЛИЙН АЖИЛ ХИЙХ ГАЗРУУД, ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН АГУУЛГА ҮЕ ШАТУУД

Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажил 3500 га талбайд:

Багц № 1: Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ойн санд 2000 га талбайд;

талбайд;

Багц № 4: Дорнод аймгийн Баян-Уул сумын ойн санд 1500 га талбайд ажлыг зохион байгуулна.

БЭЛТГЭЛ

- Багаж тоног төхөөрөмжүүдийн техникийн паспорт, техникийн үзүүлэлтүүдийг нотлох баримт бичгийг хавсарган ирүүлэх шаардлагатай.
- Өндөг хусаж цуглуулахад шаардлагатай бусад тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн, тэмцлийн ажилд гаргахад бэлэн болгосон байх;
- Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажлын хөдөлгөөнийг бүртгэх байршил тодорхойлох Earthranger платформыг гар утсанд суулган аж ахуйн нэгжийн нэр дээрх админ эрхээр замын зураглал бичих хэсгийг идэвхжүүлэн өдөр бүрийн нислэгийг замын зураглалыг Earthranger платформд илгээсэн байна; /Админ эрхийг Ойн газраас нээлгэж авна/
- Earthranger платформын эрхээр ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажил, тэмцлийн ажлын үр дүнг өдөр бүр зааврын дагуу илгээсэн байх;
- Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажлын хөдөлгөөнийг бүртгэх байршил тодорхойлох багаж /GPS/-аас өдөр бүрийн явсан маршрутын мэдээг хуулж авч хадгалах;
- Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлыг явуулах технологийн карт боловсруулах;
- Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд ашиглах 1:100000-ын байр зүйн болон 1:50000-ны масштабтай ойн тархалтын зураг дээр тэмцлийн ажил явуулах талбайг тэмдэглэх;
- Тэмцлийн ажлын өдөр тутмын гүйцэтгэлийг бүртгэх загвар бэлтгэсэн байх;
- Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд ажиллах

ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгч, тухай бүрд нь зааварчилгааны хуудас дээр

дадлагажуулан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх;

- Тэмцлийн ажил явуулах бүс нутгийн ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тухай мэдээ, зураглалтай танилцах, тэмцлийн ажил явуулах газар нутгийг судлан холбогдох бэлтгэлийг хангана

**ӨНДӨГ ХУСАЖ
ЦУГЛУУЛАХ
МЕХАНИК АРГААР
ТЭМЦЭХ**

Доор дурдсан аймгуудын ойн сан бүхий сумдад тэмцэх ажлыг зохион байгуулна. Үүнд:

д/д	Тэмцлийн ажил явуулах сумын нэр	Тэмцэл явуулах талбай, га
1	Дорнод аймгийн Баян-Уул сумын ойн санд механик тавих аргаар тэмцэх	1500
НИЙТ ДҮН		1500

д/д	Техникийн шаардлага	Нийлүүлэгчийн санал
1.	400 нанометрээс багагүй хэмжээтэй дусал бүхий мананцар үүсгэн ажлын шингэнийг шүрших боломжтой шүршигч багажуудтай байх	
2.	Өндөг хусаж цуглуулах хусуур, цуглуулах савтай байх	
3.	Түүсэн өндөгний хэмжээг гаргах электрон эсвэл гаржинтэй байх	
4.	Үүргийн шүршигч багажууд нэг удаагийн цэнэглэлтээр 0.5 га-аас багагүй талбайг хамран шүршилт хийх боломжтой байх	
5.	Шүршигч тоног төхөөрөмжийн моторын хүчин чадал 5 м.х-ээс багагүй байх ба шүрших өндөр нь 8 метр болон түүнээс их байх	
6.	Бүрэн ажиллагаатай бэлдмэл бодис сорох гаргах мотопомптой байх.	
7.	Ажил гүйцэтгэх хугацаанд багажийн техникийн үзүүлэлтээс хамааран 20-25 хоногийн хугацаанд багтаан тэмцлийн ажил явуулах боломжтой хэмжээний үүргийн шүршигч багажуудтай байх	
8.	Ажлыг гүйцэтгэх хугацаа: 2024.08.20– 2024.09.10	

Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авахдаа 1000 га хүртэлх талбайд 100 га тутамд нэг хяналтын дээж талбай, 1000 га-аас

дээш талбайд 500 га тутамд нэг хяналтын дээж талбай байгуулан тэмцлийн ажил явуулахаас өмнө болон дараа нь тооллого хийн үр дүнг тооцсон байна.

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх бүс нутагт хяналтын талбай байгуулан тэмцлийн өмнөх болон дараа харьцуулсан үр дүнг гаргасан байна.

Тэмцлийн ажлын өмнөх судалгаа болон тэмцлийн ажлын үр дүн тооцох тус тус хүснэгтийг зааврын дагуу газар дээр нь бөглөсөн байх;

Тэмцлийн ажлын өдөр тутмын гүйцэтгэлийг хэсэглэл, ялгарал, газрын нэрээр гаргах, өдөр бүрийн түүсэн өндөгний жинг гаргаж, тэмцлийн ажлын маршрут, хөдөлгөөнийг байршил тодорхойлогч багажаар бүртгэн явсан замыг ship өргөтгөлтэй файлаар хадгалах, ойн тархалтын зураг дээр тэмдэглэн танилцуулах зураг бэлтгэн товч тайлан гарган ажиллана.

Уг гүйцэтгэлийн өдөр тутмын товч тайлан мэдээг ажлын гүйцэтгэлд хяналт тавьж буй төслийн менежерийн анхны шаардлагаар саадгүй хувиан өгөх үүрэгтэй.

Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажлын хөдөлгөөнийг бүртгэх байршил тодорхойлох Earthranger платформыг гар утсанд суулган аж ахуйн нэгжийн нэр дээрх админ эрхээр замын зураглал бичих хэсгийг идэвхжүүлэн өдөр бүрийн нислэгийг замын зураглалыг Earthranger платформд илгээсэн байна; /Админ эрхийг Ойн газраас нээлгэж авна/

Earthranger платформын эрхээр ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажил, тэмцлийн ажил, тэмцлийн ажлын үр дүнг өдөр бүр зааврын дагуу илгээсэн байна;

Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажлын байршил тодорхойлох багаж /GPS/-аас өдөр бүрийн явсан маршрутын мэдээг хуулж авч хадгалах;

Ойн хөнөөлт шавж, өвчний нарийвчилсан судалгаа хийх, суурин цэг байгуулах, тархалт, голомтыг тогтоох судалгааны ажлын явцын болон гүйцэтгэлийн мэдээ, видео, фото зураг хэлбэрээр тухайн орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл цахим социал сувгаар мөн захиалагч байгууллага Ойн газрын хэвлэл мэдээллийн хариуцсан мэргэжилтэнд өдөр тутмын мэдээг тогтмол өгсөн байна.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг тухайн багцад ажиллах инженер, техникийн ажилтныг ажилласан байна. /Тухайн багцын удирдах болон инженер, техникийн ажилтнууд ажиллуулаагүй тохиолдолд гэрээт ажлыг гүйцэтгэх боломжгүй гэж үзэн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна./

Ойн хөнөөлт шавжтай Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажлыг гүйцэтгэхдээ “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6532:2015”, стандартыг мөрдөж ажиллана.

Тэмцлийн ажлын өдөр тутмын гүйцэтгэлийг хэсэглэл, ялгарал, талбайн байршлыг хадгалах, ойн тархалтын зураг дээр тэмдэглэн танилцуулах зураг бэлтгэх, газрын нэрээр гаргах, өдөр бүр

түүсэн өндгийг жинлэн фото зургаар баталгаажуулан орон нутгийн ажлын хэсгийн төлөөллийг байлцуулан хогийн цэгт нүх ухаж булж устгасан товч тайлан гарган ажиллана.

**Тэмцсэн талбайг
хүлээлгэн өгөх**

Тэмцлийн ажил явуулсан талбайг орон нутгийн эрх бүхий албан тушаалтнаар батлуулан, захиалагчаас томилогдсон төслийн менежер, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгч, актыг хавар, намар гэсэн хоёр үе шатаар үйлдэн актын эх хувийг тайланд хавсарган ирүүлнэ.

Тэмцлийн ажлын үр дүнг тооцохдоо “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6534:2015” стандартыг мөрдөж ажиллана. Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авахдаа 1000 га хүртэлх талбайд 100 га тутамд нэг хяналтын дээж талбай, 1000 га-аас дээш талбайд 500 га тутамд нэг хяналтын дээж талбай байгуулан тэмцлийн ажил явуулахаас өмнө болон дараа нь тооллого хийн үр дүнг тооцон хүлээн авна.

Тэмцлийн ажлын техникийн үр дүн 90%-аас багагүй байхад тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авна..

**Зөрчил, гологдол
арилгах**

Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авахад гарсан зөрчил дутагдлыг гүйцэтгэгч залруулах үүрэгтэй.

Тэмцлийн ажлын үр дүн заасан хувь хэмжээнд хүрээгүй тохиолдолд гүйцэтгэгч тэмцлийн ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж дахин комисст хүлээлгэн өгнө.

Энэхүү шаардлагыг биелүүлж ажиллахаа тендерт оролцогч захиалагчид албан бичгээр тодорхойлолт гаргаж өгөх үүрэгтэй.

Тайлан боловсруулах

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайланг аймаг тус бүрээр хийж захиалагчид 2 хувь ирүүлнэ. Тайлан доор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

а/ “Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан”;

б/ 1:50000-ны масштабтай ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцлийн ажил явуулсан талбайн зураг;

в/ 1: 100000-ны масштабтай ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тойм зураг.

а. “Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан”-д:

Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын судалгаа явуулан хөнөөлт шавжийн тархалт, голомт, хөнөөлийн голомт, дахин сэргэн ургах чадвараа алдсан талбайг ой зохион байгуулалтын материалын хэсэглэл ялгарлын талбай бүрээр гарган хүснэгтээр оруулна.

Түүнчлэн зонхилон хөнөөл учруулж буй шавжийн зүйлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн биологи, экологийн зарим онцлог шинжүүд, хөгжлийн үе шатуудын талаарх мэдээлэл, тоо толгойн нягтшил, хэт олшролын өнөөгийн байдал, өсөлтийн динамик,

цаашид авах арга хэмжээний талаарх мэдээллийг багтаана.

Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, хөнөөлт шавжид нэрвэгдсэн ойн ерөнхий байдлын зураг, тэмцлийн ажлын үр дүнд ой сэргэн ургасан байдлыг харьцуулсан зургийг тайланд хавсаргана.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын бэлтгэл, зохион байгуулалт, гүйцэтгэсэн хугацаа, бүрэлдэхүүн, ажил гүйцэтгэсэн технологийн мэдээлэл, тэмцлийн ажил явуулсан талбайн мэдээллийг тайланд багтаах ба тэмцлийн ажил явуулсан талбайн зураг, орон нутагт хүлээлгэн өгсөн актыг эх хувиар хавсарган ирүүлнэ.

Түүнчлэн тэмцлийн ажил эхлэхийн өмнө дээж талбай байгуулан хөнөөлт шавжийн нягтшилыг тодорхойлсон мэдээллийг дээж талбай тус бүрээр, үр дүнг тооцохоор байгуулсан дээж талбай дээрх тооллогын мэдээллийг тооллого хийсэн өдөр тус бүрээр гарган тайланд оруулна.

б. “Ойн хөнөөлт шавжтай тэмцсэн ажил явуулсан талбайн зураг”-т: Хэсэглэл, ялгарлын хил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлолд, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.

Тэмцлийн ажил явуулсан талбайг арга тус бүрээр ялган харуулах ба талбайн хэмжээг тусад нь хүснэгтэд хийн зурагт хавсарган ирүүлнэ.

Ойн хөнөөлт шавжтай тэмцлийн ажил явуулсан талбайн зургийг сум тус бүрээр гарган тайланд хавсаргана.

в. “Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тойм зураг”-т ойн хөнөөлт шавж, өвчний тархалтыг зүйлийн бүрэлдэхүүн тус бүрээр гарган харуулна. Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тойм зургийг сум тус бүрээр гарган тайланд хавсаргана.

Тайланг захиалагчийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ.

Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно.

Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтийн тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагийг хэрэглэнэ.

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан болон зургийн shr.файлуудыг цахим хэлбэрээр /CD, DVD/ 1 хувь ирүүлнэ.

**Тайланг хэлэлцүүлэн
хүлээлгэн өгөх**

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлын тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Захиргаа, удирдлагын хэлтэс, Ойн нөөцийн хэлтэст тус тус нэг хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгасан болно. Тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт нээлттэйгээр хэлэлцүүлнэ.

**МЭРГЭШСЭН
ИНЖЕНЕР
ТЕХНИКИЙН
АЖИЛЧДЫН
ХАНГАМЖИД
ТАВИГДАХ
ШААРДЛАГА**

Тэмцлийн ажлыг зохион байгуулахад мэргэшсэн инженер техникийн болон улирлын ажилтнууд нь доорх шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

Ерөнхий инженер нь ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил ажил гүйцэтгэсэн 5 жилийн туршлагатай байх, түүн дотроо гэрээг бие даан хариуцаж ажилласан 3 жилийн туршлагатай байх
Инженер техникийн ажилтан нь ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил ажил гүйцэтгэсэн 3 жилийн туршлагатай байх
5.0 мян/га талбай тутамд ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд 5-аас дээш жил ажилласан мэргэшсэн инженер 2-ээс доошгүй, 5.0 мян/га талбай тутамд улирлын болон түр ажилтан 20-оос доошгүй байна.
Тэмцлийн ажлыг зохион байгуулахад бусад шаардлагатай ажилчидтай /тогооч, жолооч гэх мэт/ байх.

ЗУРАГ

*Ойн хөнөөлт шавжтай өндөг хусаж цуглуулах
механик аргаар тэмцэх талбайн байршил харуулсан зураг*

/Хавсралт 1/

Зураг төслийн жагсаалт /тендерт оролцогч ирүүлэх/

д/д	Зураг төслийн нэр	Агуулга
1.	Тэмцлийн ажил явуулах талбайн зураг	Тэмцлийн ажил явуулахаар төлөвлөж буй аймаг, сум тус бүрээр гаргах ба ажил гүйцэтгэх арга технологи тус бүрээр газар нутгуудыг тэмдэглэх, ажил гүйцэтгэх хугацааг харуулсан байх
2.	Тэмцлийн ажилд ашиглах багажийн зураг	Багажийн маркийг бүрэн гүйцэд харуулсан байх
3.	Тэмцлийн ажилд ашиглах автомашинуудын зураг	Ажилд ашиглах машинуудын зургийг тус бүрд нь харуулах
4.	Тэмцлийн ажилд ажиллах мотопомпнуудын зураг	Мотопомпнуудын марк, ус шахах, сорох шланжыг бүрэн гүйцэд харуулсан байх
5.	Тэмцлийн ажилд ашиглах үүргийн шүршигч багажийн зураг	Шүршигчийн марк, үзүүлэлтүүдийг гүйцэд харуулсан байх

ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

д/д	Ажлын нэр, тодорхойлолт	Тоо, хэмжээ	Нийлүүлэх хуваарь
1	Бэлтгэл ажил	-	2024-08-15-ны дотор
2	Механик аргаар тэмцэх ажил /намар/	1500 га	2024-08-20-ны дотор
3	Тэмцсэн талбайг хүлээлгэн өгөх /намар/	1500 га	2024-09-10-ны дотор
4	Зөрчил, гологдол арилгах /намар/	1500 га	2024-09-10-ны дотор
5	Тайлан боловсруулалтын ажил	-	2024-10-10-ны дотор
6	Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх	-	2024-11-10-ны дотор